



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

20 20 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 0/179

Алтай хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2019 оны 20, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 73 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 27, 28 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх шийдвэрийн дагуу “Алтайн баялаг хөгжлийн сан” ТББ-тай байгуулсан гэрээний дагуу тус сангийн Хаан банкны харилцах дансанд төвлөрсөн 35481767 төгрөг, Төрийн банкны харилцах дансанд төвлөрсөн 2879573 төгрөгийг тус төрийн бус байгууллагын дансаар дамжуулан хандив өгсөн байгууллагуудад буцаан олгосугай.

2. Ойн бэлтгэл ажлын хүрээнд аймгийн удирдлагуудын Улаанбаатар хотод ажиллах унаа болон бусад зардалд 5000000 төгрөг, 80 жилийн ойд зориулан хийлгэсэн хүндэт тэмдэг, үнэмлэхний үнийн үлдэгдэл 5138660 төгрөг, тээврийн зардал 65000 төгрөгийг тус тус зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Уг зардалд нийт 48565000 төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ойн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирлагын хэлтэс (Ж.Мөнхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

